



**БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ**

2024 оны 04 сарын 05 өдөр

Дугаар А/08

Улаанбаатар хот

Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит
сонгуулийн сурталчилгааны самбар
байрлуулах байршил тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.3 дахь хэсэг, 42 дугаар зүйлийн 42.1.3 дахь заалт, 42.2 дахь хэсгийг тус тус үндэслэн дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит XXV хуралдаанаас **ТОГТООХ** нь:

1. Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн тойрогт нэр дэвшигчдийн нэгдсэн самбарын байршлыг нэгдүгээр, нам эвслийн сонгууль эрхэлсэн байгууллагын зурагт самбар байрлуулах байршлыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Тойрогт нэр дэвшигчдийн нэгдсэн самбарыг тогтоосон шаардлагын дагуу бэлтгэж, хуулийн хугацаанд байрлуулж ажиллахыг Засаг даргын Тамгын газар (Л.Санжийжамц)-т үүрэг болгосугай.

3. Тогтоолыг Сонгуулийн Ерөнхий хороонд хүргүүлэх, нийтэд мэдээлэх, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын алба (М.Давааням), Засаг даргын Тамгын газар (Л.Санжийжамц)-т тус тус даалгасугай.

ДАРГА



Ф.МӨНХГЭРЭЛ

Нийслэлийн Багахангай дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ээлжит ~~ХХ~~ хуралдааны 2024 оны ~~04~~ дүгээр сарын ~~05~~ -ны өдрийн ~~1108~~ дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт

БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН ХОРООДЫН НУТАГ ДЭВСГЭРТ
БАЙРЛУУЛАХ НЭГДСЭН САМБАРЫН БАЙРШИЛ

№	Хэсгийн хороо	Байршил	
1.	1 дүгээр хороо	Өндөртолгой, Төв талбай хойд хэсгийн гэрэлт гудамжны ногоон байгууламж	
		Өндөртолгой, Нуман хаалганы хойд талын барилгын хашаа	
		Алтгана гэр хороолол, Алтгана 01а-03тоот хашааны урд тал	
		Үнэгтэй гэр хороолол, Үнэгтэй 02-01 тоот хашааны зүүн тал	
2.	2 дугаар хороо	Хангай хотхон, хуучин Төмөр замын эмнэлгийн зүүн тал	
		“Хангай” цогцолбор сургуулийн хичээлийн 2 дугаар байрны хөл бөмбөгийн талбайн хойд тал	
		Нуурын гэр хорооллын хүүхдийн тоглоомын талбай,	3х3 сагсан бөмбөгийн талбайн баруун тал
		Бор үзүүр, Цайдамын гэр хорооллын ус түгээх худгийн зүүн тал	
Нийт		8 байршил	

Нийслэлийн Багахангай дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын Ээлжит ^{ХН}хуралдааны 2024 оны 04 дүгээр сарын
05-ны өдрийн 1/08 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН ХОРООДЫН НУТАГ ДЭВСГЭРТ НАМ ЭВСЛИЙН
СОНГУУЛЬ ЭРХЭЛСЭН БАЙГУУЛЛАГЫН ЗУРАГТ САМБАР
БАЙРЛУУЛАХ БАЙРШИЛ

№	Хэсгийн хороо	Байршил
1.	1 дүгээр хороо	Нуман хаалганаас Үнэгтэй гэр хороолол хүртэл авто зам дагуу, Төв талбай, Үнэгтэй гэр хорооллын хүүхдийн тоглоомын талбайн хэсэг Илч-Орд ОНӨААТҮГ-аас Алтгана гэр хороолол хүртэл явган хүний зам дагуу, Алтгана гэр хорооллын хүүхдийн тоглоомын талбайн хэсэг
2.	2 дугаар хороо	Замчин гэр хорооллын 1.3 км авто замын уулзвараас Хангай хотхон хүртэл авто зам дагуу, Хангай хотхоноос Төмөр замын бизнес төв хүртэл явган хүний зам дагуу, Хангай хотхоны төв талбай, хүүхдийн тоглоомын талбайн хэсэг 2 дугаар хорооны цогцолбор байрнаас Бор үзүүр, Цайдамын гэр хороолол хүртэл явган хүний зам дагуу, Нуур, Замчин, Бор үзүүр, Цайдамын гэр хорооллын хүүхдийн тоглоомын талбайн хэсэг
Нийт		4 байршил